

## СУРАХЫН БАЯР АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

1. Дүүргийн Засаг дарга, ЮНЕСКО-гийн Монгол үндэсний комиссын төлөөлөгчид болон Насан туршийн суралцахуйн төвийн удирдлага оролцож, туг залах ажиллагааг ёслол төгөлдөр гүйцэтгэж Баянгол дүүрэг “Дэлхийн суралцагч хот”-ыг албан ёсоор тунхаглагдлаа.






2. **Үндэсний бичиг:** Дүүргийн төрийн албан хаагчид болон бүх насны иргэдэд үндэсний бичгийн танхимын болон цахим 148 удаагийн сургалт зохион байгуулж 1269 иргэнийг хамруулсан. Цахим хуудсаараа 85 удаагийн постер мэдээлэл бэлтгэж 35 550 иргэнд хүрсэн. Хүрсэн үр дүнгийн үнэлгээ хийж 100 иргэнд “Сурахын баяр”-ын батламж гардуулсан.



3. **Оёдол эсгүүр:** Оёдол эсгүүрийн сургалт Дүүргийн 492 иргэнийг хамруулсан бөгөөд дээл, цамц, өмд зэргийг өөрийн гараар урлаж сурсандаа баяртай байлаа.



4. Юнеско-гийн Суралцагч хот болсноор багш, менежерүүд Юнеско-гийн Насан туршийн хүрээлэнгийн Дижитал бичиг үсгийн ур чадварын сургалтад хамрагдаж Батламж авсан бөгөөд Дүүргийн 1225 багш, албан хаагчид тус сургалтад хамрагдаж байна.



Тайлан нэгтгэсэн менежер С.Соёл-Эрдэнэ 2026.06.10

**Байгууллагын албан ёсны хаяг:**

**Хаяг байршил:** Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18-р хороо

**Холбоо барих утас:** (976) 7707-0110

**Цахим шуудан:** bgd-llc@agency.edu.mn

